



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
191 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.22 дахь заалтыг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ганзоригийн Эрдэнэбулганыг 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөр тасалбар болгон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Г.Эрдэнэбулгантай холбогдох тооцоо хийж дуусгахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Х.Цэцэгмаа/-д даалгасугай.

ДАРГА

Т.ЛХАГВАСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
191 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг түр томилох тухай**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 159 дүгээр тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.22 дахь заалтыг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Бат-Эрдэмийн Төрбатыг Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан эрх үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэн ажиллахыг Б.Төрбатад даалгасугай.
3. Б.Төрбатыг ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэхийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

**ДАРГА**

**Т.ЛХАГВАСҮРЭН**